



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/353

Хэрлэн сум

Зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд зориулж,  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 2022 оны "Аймгийн 2022 оны төсөвт тодотгол хийх тухай" 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор "Шинэ эрин" олон улсын сургууль нь менежментийн гэрээний дагуу Бэрх хотын олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургуульд зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа тул эхний шатны санхүүжилт болох 40,000,000 (дөчин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах хөрөнгийг Засаг дарга дансны Ерөнхий боловсролын сургуульд олон улсын стандарт нэвтрүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Өнөрцэцэг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ